

ТАНИЛЦУУЛГА

1. Шүүх шинжилгээний тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10-д Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж заасны дагуу Хүрээлэн байгаа орчны шинжилгээ, үнэлгээ хийх журмын төслийг боловсрууллаа.

Тус журмын төсөлд эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг Шүүх шинжилгээний тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журамтай уялдуулан дараах зохицуулалтыг нарийвчлан тусгасан болно. Үүнд:

- шинжилгээ хийх нийтлэг үндэслэл, баримтлах хууль тогтоомж, зарчим;
- шинжилгээний төрөл,
- шинжилгээний лабораторид тавигдах шаардлага,
- шинжилгээ хийж дүгнэлт гаргах,
- шинжилгээний объектыг хадгалах, тээвэрлэх ерөнхий шаардлага,
- лабораторийн аюулгүй ажиллагаа, хориглох зүйл зэргийг зохицуулсан болно.

2. Хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээг:

2020 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа “Экологийн шинжилгээний лаборатори” нэртэй байгуулагдсан, хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний лаборатори.

Тус лаборатори одоогоор биологич мэргэжилтэй 2, ойн аж ахуйн инженер 1, байгаль орчныг хамгаалах технологич 1, экологи-химич мэргэжилтэй 1, экологийн инженер 1 нийт 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй нийслэл болон Ховд, Дорнод аймагт дараах чиглэлээр шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- **амьтан судлалын шинжилгээ** (ангиал зүй, нас, хүйс, статус, экологи эдийн засгийн үнэлгээ, тархац нутаг);
- **мод судлалын шинжилгээ** (ангиал зүй, насжилт, чийг, статус, эзлэхүүн /мЗ/, экологи-эдийн засгийн үнэлгээ /мужлал/);
- **ургамал судлалын шинжилгээ** (ангиал зүй, статус, чийг, экологи эдийн засгийн үнэлгээ, тархац нутаг);
- **хөрсний шинжилгээ** (хөрсний чийг, температур тодорхойлох, хөрсний даралт нэвтрүүлэх чадвар, хөрсний орчин /РН/ тодорхойлох, хөрсний зарим хүнд металл);
- **усны шинжилгээ** (усанд ууссан хүчилтөрөгчийн хэмжээ, усны хурд, температур тодорхойлох, усны орчинг тодорхойлох, усны цахилгаан дамжуулах чанар, усанд ууссан хатуу бодисын хэмжээ);
- **бусад шинжилгээ** (агаарт 16 төрлийн хий, PM2.5, PM10, TVOC агууламж тодорхойлох, дуу чимээний түвшин хэмжих, эвдэрсэн газрын хэмжээ, ургамлын бүрхэвч, нөлөөллийн бүсийг тогтоох, зураглал гэх мэт)б

2021 онд 4 шинжилгээ, 2022 онд 53176 объектод нийт 92 шинжилгээ хийснээс мод судлалын 55, ургамал судлалын 8, амьтан судлалын 27, бусад 2 шинжилгээ хийж 46,099,380,427 төгрөгийн экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоож, 26 хэргийн газрын үзлэгт явж ажилласан.

2023 оны эхний 1 сарын байдлаар 850 объектой 38 шинжилгээ хүлээн авснаас амьтан судлалын 21, мод судлалын 13, бусад 4 шинжилгээ хүлээн авснаас 115,257,819 төгрөгийн экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоож ажилласан.

2022 оны шинэчлэн найруулсан “Шүүх шинжилгээний тухай” хуулиар тус лабораторийн үйл ажиллагааг тухайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт бүхий хэсгийг тусгасан нь лабораторийн хөгжилд чухал ач холбогдолтой зохицуулалт болсон.

Энэхүү журмын төсөл батлагдсанаар Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 38 дугаар зүйл хэрэгжих эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бий болох бөгөөд шинжилгээ хийх үйл ажиллагаа, шинжээчийн дүгнэлт хууль, шүүхийн байгууллагад хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтын эх сурвалж болох хууль эрх зүйн үндэслэл бүрэлдэх юм.

---oOo---